



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

120 /120/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.08.25

ҮЙЛ ЯВДАЛ

БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д.ГАНХУЯГ “АРМИ-2021” ОЛОН УЛСЫН ЦЭРЭГ-ТЕХНИКИЙН ФОРУМД ХҮНДЭТ ЗОЧНООР ОРОЛЦЛОО



БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг 8 дугаар сарын 23-ны өдөр нээлтээ хийсэн 7 дахь удаагийн “АРМИ-2021” олон улсын цэрэг-техникийн форумд хүндэт зочноор оролцлоо. ОХУ-ын Москва мужид байрлах “Патриот” паркард зохион байгуулж буй тус форумд Оросын болон гадаадын 1400 гаруй компани, 28000 орчим нэр төрлийн цэргийн зориулалттай бүтээгдэхүүнийг танилцуулсан юм. Тус арга хэмжээний үеэр бригадын генерал Д.Ганхуяг ОХУ-ын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны холбооны албаны орлогч захирал, Цэрэг-техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын хамтарсан ажлын бүлгийн

Оросын талын хэсгийн дарга В.Н.Дрожжовтой танилцах уулзалт хийв. Уулзалт найрсаг, халуун дотно өрнөж хоёр талын цэрэг-техникийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн юм. Тухайлбал, цар тахлын нөхцөл байдлын улмаас 2020 онд зохион байгуулагдаагүй Монгол-Оросын цэрэг-техникийн хамтын ажиллагааны хамтарсан ажлын бүлгийн хуралдааныг энэ онд зохион байгуулахаар тохиролцлоо. Мөн “Арми игры-2021» олон улсын цэргийн наадмын “Танкийн биатлон” тэмцээнд оролцож байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний баг, тамирчидтай уулзаж амжилт хүссэн юм.

МЕДАЛИЙН БУУХИА ҮРГЭЛЖИЛСЭЭР



ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас Тува Улсын нийслэл Кызыл хотод зохион байгуулж буй “Цэргийн ралли-2021” олон улсын тэмцээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид анх удаагаа оролцож байгаа хэдий ч, олон жил оролцсон туршлагатай баг тамирчидтай ижил түвшинд өрсөлдөж байна. Багийн ахлагчаар ЗХЖШ-ын МТГ-ын даргын орлогч, Техникийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Төрмөнх, дасгалжуулагчаар Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагч, хурандаа М.Батдорж нар ажиллаж байгаа юм.

Д.Бямбабаяр жолооч, ахлах ахлагч С.Амартүвшин нар 4 дүгээр байрыг тус тус эзэлсэн амжилт үзүүлэв.

Хоёрдугаар шатны “Хөөх” уралдаан өчигдөр зохион байгуулагдсан бөгөөд “Урал 6x6” ангилалд чиглүүлэгч, ахлах дэслэгч Б.Мөнгөнхуяг, жолооч, ахлах ахлагч Б.Алтанхуяг нар алт, “Урал 4x4” ангилалд чиглүүлэгч, ахлах дэслэгч Б.Ариунбаатар, жолооч, сургагч ахлагч Х.Ширмэнхоовон нар хүрэл медаль хүртэж, “Камаз 6x6” ангилалд чиглүүлэгч, дэслэгч Д.Бямбабаяр, жолооч ахлах ахлагч С.Амартүвшин нар 4, “Камаз 4x4” ангилалд чиглүүлэгч, дэслэгч М.Шийрэвноров, жолооч, ахмад П.Ганхуяг нар 5 дугаар байраар тус тус эзэллээ.

Ташрамд дурдахад 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр буюу өнөөдөр тэмцээний 3 дугаар шатанд багийн буудлага (5.45 мм-ийн АКМС-74) болон пулемётын (7.62 мм-ийн ПКТ) буудлагын тэмцээнтэй бол 8 дугаар сарын 27-ны өдөр тэмцээний 4 дүгээр шат буюу багийн уралдаанд манай баг тамирчид тус тус өрсөлдөнө.



Нэгдүгээр шатны уралдаан энэ сарын 23-ны өдөр нэг бүрийн уралдаанаар эхэллээ. Тус уралдааны “Урал 4x4” ангилалд чиглүүлэгч, ахлах дэслэгч Б.Ариунбаатар, жолооч, сургагч ахлагч Х.Ширмэнхоовон нар хүрэл медаль, “Камаз 4x4” ангилалд чиглүүлэгч, дэслэгч М.Шийрэвноров, жолооч, ахмад П.Ганхуяг нар 5 дугаар байр эзэлсэн бол “Урал 6x6” ангилалд чиглүүлэгч, ахлах дэслэгч Б.Мөнгөнхуяг, жолооч, ахлах ахлагч Б.Алтанхуяг нар, “Камаз 6x6” ангилалд чиглүүлэгч, дэслэгч



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 197,841 +1596	ЭДГЭРСЭН 182,640 +2022	НАС БАРСАН 907 +5
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4479 +80	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 168 +24	ЭДГЭРСЭН 4224 +15
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 213,947,261
Эдгэрсэн Нийт: 191,437,838
Нас барсан Нийт: 4,463,914

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
14	3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.849.0	2.852.0
EUR	3.351.0	3.360.0
CNY	440.0	441.0
RUB	37.80	39.00
JPY	25.73	26.17
KRW	2.39	2.48

ЗУРХАЙ

2021.08.25 ЛХАГВАГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 18/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ТАВАН ШАР ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эд МАЛЫН ГАРЛАГАТАЙ
Наран ургах, шингэх:
06.01-19.48
Барилдлага:
Рашаан
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй
Суудал:
Уул

Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биесийн тамырыг сэргээх, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Урага мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой.

Дашнямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



249 ХҮНИЙ ЭРДЭНЭТ АМИЙГ АВАРЛАА



Өнгөрөгч сард Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн "Амьдрал бэлэглэе" аянд нэгдэн Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвтэй хамтран ажилласан юм. Энэ хүрээнд 83 цэргийн алба хаагч цусаа хандивлан 249 хүний амийг аварлаа. Нэг хүний өгсөн 350-400 мл цус нь 3 хүнд амьдрал бэлэглэж, гурван гэр бүл элэг бүтэн, аз жаргалтай амьдрах боломжийг бүрдүүлдэг аж. Ангийн нийт бүрэлдэхүүний дунд цусны "Хүндэт донор" нэг, 20 орчим хувь нь тогтмол цусаа хандивлагч

донор байгаа бөгөөд бидний бэлэглэж буй цус төрхийн хүндрэлтэй эхэд, томоохон мэс ажилбарууд, осол гэмтэлд өртсөн, хорт хавдар, цус, цусан бүтээгдэхүүн шаардлагатай өвчин эмгэгтэй хүмүүсийн амь насыг аврахад зориулагддаг. Түүнчлэн 18-50 настай, 45 кг-аас дээш жинтэй, архаг хууч өвчингүй, эрүүл хүн бүхэн донор юм. "Донорын тухай Монгол Улсын Хууль"-ийн тавдугаар зүйлийн 22 дугаар зүйлд "Цусны донорын үйлсэд идэвхтэй оролцсон иргэн,

байгууллагыг алдаршуулах, урамшуулах" талаар тусгасан байдаг. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 169 дүгээр зарлигаар 120 ба түүнээс дээш удаа цусаа хандивласан цусны "Хүндэт донор"-ыг "Шударга журам" медалиар шагнаж байхаар болжээ.

Тус ангид зохион байгуулагдсан "Амьдрал бэлэглэе" аяны талаар ЦССҮТ-ийн их эмч Г.Цэндбаяр хэлэхдээ "Ковид-19 цар тахлын үеийн цусны нөөцийг бүрдүүлж, олон хүнд эрүүл энхийг хүсэн, уриалга гарган хамт олноороо цусаа хандивлаж байгаа энэхүү явдалд маш их талархаж байна. Цусаа тогтмол өгдөг хүмүүс зүрхний шигдээс өвчнөөр өвдөх магадлал 80 хувиар бага байдаг ба цусны эргэлт хурдсаж, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо сайжирч, мартаж өвчлөлөөс урьдчилан сэргийлдэг. Цус өгснөөр цусны шинжилгээнд хамрагдаж бүх төрлийн халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх зэрэг ач холбогдолтой. Ковид-19 өвчний үед өвчтөнүүд цус бүлэгнэлт, цусны хатуурал зэрэг нийтлэг хүндрэлүүд тохиолдож байгаа. Та бүхэн цусаа өгснөөр тэдгээр хүндрэлүүдийн эрсдэлийг бууруулж, хамгаалж байгаа юм. Сар бүрийн 3-ны өдөр буюу "Цусаа бэлэглэх өдөр"-ийг дэмжин цаашдаа сайн үйлсийн аянд нэгдэж байхыг танай хамт олноос хүсмээр байна. Баярлалаа" гэв.

"DIGITAL NATION" ҮНДЭСНИЙ ХАМГИЙН ТОМ АРГА ХЭМЖЭЭ ИРЭХ САРД БОЛНО



Монгол Улсын Засгийн газар харилцаа холбоо, мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэгээр зарлаж, "Цахим үндэстэн" санаачилгыг гаргаад байгаа. Уг салбарын хамгийн том үзэсгэлэн "ICT EXPO" энэ жилээс эхлэн "Digital nation" үндэсний хамгийн том арга хэмжээ болон 9 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Үндэсний соёл, амралтын хүрээлэнд зохион байгуулагдах гэж байна.

Цар тахлын энэ үед мэдээллийн технологийн салбарын ач холбогдол бидний алхам тутамд мэдрэгдэж, орон зай, цаг хугацаанаас үл хамаарах ухаалаг, шинэ эгэл амьдралын хэв маяг нэгэнт бүрэлдэж байна. Цаашлаад нийгмийн бүхий л салбарын

хөгжлийн хурдасгагч болсон мэдээллийн технологи, дижитал шилжилтийн иргэд, олон нийтэд илүү ойртуулах, салбарын тоглогчдын хамтын ажиллагааг дэмжиж, шинэ технологийг нийтэд танилцуулах, гарааны бизнес эрхлэгчдэд дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулж, хөрөнгө оруулагчидтай холбогдох зэрэг олон боломжийг "Digital nation-2021" бүрдүүлж байна.

Энэ жил Монгол Улсад орчин цагийн харилцаа холбооны салбар үүссэний 100 жилийн ой тохиож байгаагаараа онцлог. Энэ ч утгаараа "Digital nation-2021" арга хэмжээний үеэр салбарын өнгөрсөн, одоо, ирээдүйг хэлэлцэх, цаашид өсөн нэмэгдэх мэдээллийн технологийн

салбарын ач холбогдол, бусад салбаруудтай уялдаа холбоог нягтруулах бодлогын хэлэлцүүлэг, форум зохион байгуулагдах юм.

Нийслэл Улаанбаатар хотын төвд, Үндэсний соёл, амралтын хүрээлэнд гурван өдрийн турш үргэлжлэх арга хэмжээний үеэр төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем "e-Mongolia"-гийн шинэчилсэн хувилбарыг танилцуулахын зэрэгцээ 5G сүлжээнд шилжих, олон нийтэд танилцуулах арга хэмжээг болно. Түүнчлэн цахим спорт, соёл урлагийн хэсэг зэрэг олон нийтийг хамарсан өргө хэмжээний үйл ажиллагаа болох гэж байна.

Үзэсгэлэнд оролцох хүсэлтэй байгууллагууд www.digitalnation.mn сайтаас талбайгаа захиалах боломжтой.

ЦЭРГИЙН АЖИГЛАГЧ ОФИЦЕР, СЕКТОР КОМАНДЛАГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, сектор командлагчийн сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-тай танилцаж,

НҮБ-ын цэргийн ажиглагч, штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

- 1.Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
- 2.Ажил байдлын тодорхойлолт;

3. Ж о л о о н ы

үнэмлэхийн хуулбар; 4.Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар; 5.Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4x6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;

- 6.Товч судалгаа;
- 7.Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт. Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982, 92096622/-тэй холбогдож тодруулж болно.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын төв штаб дараах ажлын байранд үүрэг гүйцэтгэх (P-3, P-4, P-5) сонирхолтой офицеруудын сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 1-3-ны өдрүүдэд зохион байгуулна. Үүнд:

- Сургалтын офицер P-4
- Дүн шинжилгээний офицер P-3
- Сургалтын офицер P-3
- Дүн шинжилгээний офицер P-4
- Энхийг сахиулах ажиллагаа хариуцсан

офицер P-4 -Төлөвлөлтийн офицер P-4 (Хүний нөөц, бодлого төлөвлөлт) -Холбогч офицер P-4 -Цэргийн зөвлөхийн туслах P-5 Ахлах холбогч офицер P-5 -Сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ"-ыг судлан танилцаж, НҮБ-ын штабын

ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор харьяа командлал, газар, хэлтсээр дамжуулан саналаа ирүүлнэ. Холбогдох албан тушаалын жагсаалт, тавигдах шаардлага, дэлгэрэнгүй мэдээллийг psod@mil.gov.mn цахим мэйл хаягаар болон 3203, 92115982, 92096622 утсаар холбогдож тодруулж болно.

НЭГДҮГЭЭР АНГИД ЭЛСЭГЧДИЙН БҮРТГЭЛ ӨНӨӨДӨР ХААГДАНА



Нэгдүгээр ангид элсэн орж буй сурагчдыг улс даяар цахим хэлбэрээр бүртгэж байгаа. Шинэхэн сурагчдын цахим бүртгэл 8 дугаар сарын 16-ны 09:00 цагт эхэлсэн бөгөөд 8 дугаар сарын 23/19:00 цагийн байдлаар улсын хэмжээнд нэгдүгээр ангид элсэн сурагчдын 42 хувь нь сургуульдаа бүртгүүлж, бүртгэлээ баталгаажуулжээ.

Нийслэлийн хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд 40.330 хүүхэд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэн суралцах юм.

Тэдний 44.2 хувь нь л бүртгүүлсэн бол

- Багануур дүүрэгт

- бүртгэл 29.5,
- Багахангайд 47.4,
- Налайхад 56.9,
- Баянголд 46.4,
- Баянзүрхэд 41.9,
- Сонгинохайрханд 50.3,
- Сүхбаатарт 43.1,
- Хан-Уулд 42.5,
- Чингэлтэйд 37.3

хувьтай байна. Цахим бүртгэл 8 дугаар сарын 25-ны 17:00 цагт хаагдана. Гэтэл улс, нийслэлийн хэмжээнд бүртгэлийн ирц хангалтгүй, хүүхэд багачуудын тал хувь нь ч бүртгүүлж амжаагүй байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран нэгдүгээр ангид элсэн зургаан настай хүүхдүүдийг гэрийн хаягийн дагуу хамран сургах тойргийн сургуульд нь бүртгэхээр болсон. Тухайн сургуульд суралцах сурагчдын нэрсийн дагуу эцэг, эхчүүд бүртгэлийг www.parent.edu.mn цахим хуудсаар баталгаажуулах учиртай. Бүртгүүлэх явц амар хялбар, системийн хувьд саатал, хүндрэлгүй байгаа хэдий ч эцэг, эхчүүд хүүхдүүдээ бүртгүүлэхгүй, бүртгэлийн явц удаашралтай байна. Иймд эцэг, эхчүүдийг бүртгэлдээ идэвхтэй хамрагдахыг Нийслэлийн Боловсролын газраас уриаллаа.